



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН
ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 2 сарын 28 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар
хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дүрмийн 3.1.2 дахь заалт, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дэргэдэх Ёс зүйн салбар хорооны 2018-12-21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталж, 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай томилон ажиллуулсугай.

2. Эмнэлгийн мэргэжилтнийг ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлж, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хийж, салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хугацаандаа ирүүлж байхыг салбар хороо /Ж.Байгалмаа/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулж, ёс зүйн хяналтын хорооны 2017 оны 23 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4. Салбар хорооны бүрэлдэхүүний мэдээллийг мэдээний санд бүртгэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны нарийн бичгийн дарга /Б.Пүрэвжав/-д үүрэг болгосугай.


ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ЦЭРЭНДАГВА

080097

Эрүүл мэндийн яамны дэргэдэх
Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн
хяналтын хорооны
2019 оны 02 дугаар сарын 28-ны
өдрийн 05 тоот тогтоолын хавсралт



Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дэргэдэх
Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүн

Эмнэлгийн мэргэжилтний
ёс зүйн салбар хорооны дарга

Ж.Байгалмаа, Талбарын тархвар судлалын
сургалтын албаны дарга

Салбар хорооны орлогч дарга

Ц.Батзаяа, Чанарын албаны чанарын менежер

Нарийн бичгийн дарга

О.Отгонцэцэг, Ерөнхий захирлын туслах

Гишүүд

Б.Гансайхан, Насанд хүрэгчдийн цочмог
гепатитын 5 дугаар тасгийн эрхлэгч

Н.Норовжаргал, Сувилахуйн албаны арга зүйч

Ж.Баярсайхан, Эрдэм шинжилгээ, сургалтын
албаны дарга

Н.Дондог, “Эрүүл мэнд-дархлаажуулалт” ТББ-
ын гүйцэтгэх захирал

Г.Орхон, Хуулийн зөвлөх